



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 17-ны өдөр

Дугаар А/46

Эрдэнэт

Төрийн болон орон нутгийн өмчийн
эд хөрөнгийн хагас жилийн тооллого явуулах
тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дах заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай 439 дүгээр тогтоол, Сангийн сайдын Маягт заавар батлах тухай 347 тушаал, Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн ажиллах журмын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хийх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. ЭМГ-ын эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 05 дугаар сарын 25-31-ны өдрүүдэд ажлын 5 хоногт зохион байгуулан, холбогдох журам, заавар, маягтын дагуу нэг бүрчлэн тоолж ажиллахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Эд хөрөнгийн тооллогын дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг комиссын дарга /Д.Отгондэлгэр/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ


Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
01. дугаар сарын 17. ний өдрийн
А/46. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын
хэсгийн бүрэлдэхүүн**

- Комиссын дарга: - Эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн
- Гишүүд: -Салбарын санхүү бүртгэл, нягтлан бодохын ажилтан
-Мэдээлэл технологи, телемедицин хариуцсан ажилтан
-Эмийн бодлогын хэрэгжилт чанар аюулгүй байдал, эмийн зохистой
хэрэглээ, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан
мэргэжилтэн
- Нярав
- Зураглаач
- Нарийн бичиг: -Статистикч бага эмч

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
06 дугаар сарын 17-ний өдрийн
А/М/6 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**Эд хөрөнгийн тооллогын комиссын хийх
ажлын төлөвлөгөө**

№	Эд хөрөнгийг тоолоход хийх ажил	Хугацаа	Хүрэх үр дүн
1	Хөрөнгийн тооллого хийх.	2022.05.25-31	Үндсэн хөрөнгийг тоолж, тооллогын бүртгэл тусгах
2	Хөрөнгийн карт эзэмшигчийн бүртгэлийг байршуулах.	2022.05.25-27	Шинэчлэгдсэн картыг тухайн албан хаагчид өгөх, өрөөнд нь байршуулж улсын үзлэгт бэлдэх.
3	Үндсэн хөрөнгө болон бусад хангамжийн хөрөнгө актлах, шилжүүлэх хөрөнгийг тоолж бүртгэх.	2022.05.25-31	Актлах болон шинэчлэх хөрөнгийг бүртгэж өмчийн албанд хүргүүлэх. Мөн ЭМГ дээр актлах хөрөнгийн тушаал гаргах
4	Тооллогын үед гарсан дүгнэлтийг УЗХ-аар оруулах	2022.06.10	Бүх гишүүд